

УЛААНБААТАР ХОТЫН ЦЭВЭРШҮҮЛЭХ БАЙГУУЛАМЖИЙН НУУР, ТҮҮНИЙ ОРЧМЫН ШУВУУДЫН ЗҮЙЛИЙН БҮРДЭЛ БА ТУЛГАМДАЖ БУЙ АСУУДАЛ

Пүрэв-Очирын Ганхуяг^{1,4}, Бархасбаатарын Ариунбаатар², Андреас Буххэйм^{2,3}, Гунгаагийн Амархүү^{2,3}, Цолмонжавын Пүрэвсүрэн², Даваасүрэнгийн Батмөнх³, Эрдэнэхүүгийн Болормөнх², Баатаргалын Отгонбаяр², Ламжавын Жаргалсайхан², Пүрэвдоржийн Амартүвшин⁴

¹Монголын шувуу хамгаалах төв, Баян Монгол хороолол, 414-143 тоот, Их Монголын гудамж, Улаанбаатар

²Монголын шувуу ажиглагчдын клуб, Юнион Бюлдинг Б-802, ЮНЕСКО-ын гудамж, Улаанбаатар 14230

³Эрлэг амьтан судлах хамгаалах төв, Юнион Бюлдинг Б-802, ЮНЕСКО-ын гудамж, Улаанбаатар 14230

⁴Монтис ХХК, Баян Монгол хороолол, 414-143 тоот, Их Монголын гудамж, Улаанбаатар

харилцах хаяг: pgankhuyag@gmail.com

хураангуй. Ногоон нуур нь Улаанбаатар хотын баруун хэсэгт оршдог бөгөөд Төв Цэвэрлэх Байгууламжийн хаягдал уснаас үүсэж тогтсон. Энэхүү байгууламж нь 1964 онд байгуулагдсан. Дотоодын шувуу судлаачид Ногоон нууранд 1995-2000 оны хооронд тогтмол шувуудын ажиглалт хийж байсан бөгөөд тэд нийтдээ 64 зүйл шувууг бүртгэсэн. Бид энэхүү өгүүлэлдээ Ногоон нуурын шувуудын ажиглалтын сүүлийн 8 жилийн мэдээг нэгтгэж үзлээ. 2008-2015 оны хооронд нийтдээ 187 зүйл шувуу бүртгэгдсэн, үүнээс 42 зүйл шувуу нь үржлийн ба Дэлхийн Байгаль Хамгаалах Холбооны олон улсын болоод бүс нутгийн шалгуураар ховор ангилалд бүртгэгдсэн 22 зүйл шувуу байна. Ногоон нуур нь дамжин өнгөрдөг болон зусдаг шувуудын хувьд таатай амьдрах орчин болжээ. Ногоон нуур нь дотоодын болон гадны шувуу ажиглагчдын хамгийн сайн мэддэг мөн очих дуртай газар болжээ. Харамсалтай нь энэхүү усан сан нь Улаанбаатар хотын нисэх онгоцны хөөрөх, буух зурвас бүсэд байршдаг учир нисэх онгоцны буудлын зүгээс нислэгийн аюулгүй байдлыг хангах үүднээс булж, аюулыг багасгах хэрэгтэй гэсэн шийдвэрийг гаргаад байна.

Түлхүүр үг: Улаанбаатар хот, хиймэл усан сан, цэвэршүүлэх байгууламжийн цөөрөм, шувуудын зүйлийн бүрдэл

abstract. Green or UB pond in Ulaanbaatar is located in the west side of the city and it was created by waste water of Central Wastewater Treatment Plant. This Plant in Ulaanbaatar was established in 1964. The regular observation of this pond has been made by a local ornithologist between 1995-2000. In the pond, he recorded 64 species of birds during his observation periods. In this article, we used our last 8 years observation data on birds at the pond. We compared our observation data with the previous data. In between 2008-2015, a total of 187 species of birds were recorded and of these, 42 species are breeding and 22 species are globally and regionally threatened under IUCN criteria. The pond has become a more suitable habitat for both migratory and breeding birds. Now this pond is well known for local and foreign birders and has become one of the top birding sites in the Ulaanbaatar. Unfortunately, this pond is located in an airplane landing zone and the airport office wants to bury the ponds in that zone for flight safety.

keywords: Ulaanbaatar, manmade reservoir, sewage ponds, species composition

Тоодог 2:17-23, 2016

Оршил

Улаанбаатар хотын айл өрх, албан байгууллага, үйлдвэрүүдийн бохир усыг хүлээн авч механик болон биологийн цэвэрлэгээний

байгууламжаар дамжуулан цэвэршүүлэн Туул голд нийлүүлэх үүрэгтэй энэхүү цэвэрлэх байгууламж нь 1964 онд байгуулагджээ. Анх байгуулагдахдаа хоногт 4500 м³ бохир ус хүлээн авч механик цэвэрлэгээгээр 50%

хүртэл цэвэрлэх хүчин чадалтай байсан бол хотын хүн ам, үйлдвэрлэл нэмэгдэхийн хирээр хүчин чадлаа нэмэгдүүлж, 1979, 1986 онуудад тус тус өргөтгөл хийн хоногт 20000м³ ахуйн бохир ус хүлээн авч 90-92% хүртэл цэвэршүүлэх хүчин чадал бүхий байгууламж болжээ. Энэ үед мөн хотын зам засварын ажил явагдаж, цэвэршүүлэх байгууламжийн орчим хайрга чулуу ашиглах зорилгоор газар ухаж түүний нөлөөгөөр овоолсон шороонууд үүсч, тэдгээрийн хонхороор нь цэвэршүүлэх байгууламжаас ялгарсан ус урсаж өнөөгийн энэхүү нуурыг бий болгосон байдаг. Хотын иргэд “өмхий нуур” гэдэг нэрээр нь мэдэх хэдий ч шувуу ажиглагчид сүүлийн хэдэн жил энэ нуурын шувуудыг тогтмол ажиглаж, хавар намрын нүүдлийн үеэр байнга очдог газраа болгосон бөгөөд нууранд замаг ихээр ургаж нуурын мандлыг бүрхдэг учир “Ногоон нуур” гэж нэрлэжээ. Энэ нуур хиймэл аргаар үүсэн өнөөгийн энэ амьдрах орчныг бий болгосон нь олон зүйл нүүдэллэн ирж, үрждэг шувуудын өндөглөн зусдаг таатай орчин болсон.


Улаанбаатар хот өргөжин тэлж, дэд бүтэц хөгжихийн хэрээр хотын цэцэрлэгт хүрээлэнгүүд тэдгээрт тохиолддог шувуудын зүйлийн бүрдлийн талаар шувуу судлаачид анхаарал хандуулан ажиглаж олон бүтээл хэвлүүлсэн байдаг (Цэвээнмядаг 1992, Болдбаатар 1997, Болд нар 2000). Харин Улаанбаатар хотын усан сангууд ялангуяа цэвэршүүлэх байгууламжаас үүсч бий болсон энэ нуурын шувуудын ажиглалт судалгааг 1995-2000 оны хугацаанд хийж тусгайлан өгүүлэл нийтлүүлж байжээ (Болд нар, 2000).

Манай хотод хамгийн ойр байх усны шувууд олноор зусаж үрждэг энэ нуурын ажиглалт судалгаа нь хотын иргэдийн хувьд ихээхэн ач холбогдолтой юм. Учир нь энэ газрыг хүүхэд багачуудад байгаль хамгаалах боловсролыг олгох эко хүрээлэн болгон хөгжүүлэх боломжтой. Ингэснээр хүүхэд багачуудыг байгалиа хайрлах сэтгэлгээг нь шувуудаар дамжуулан хөгжүүлэх боломжтой ба энэ утгаараа байгаль хамгааллын хувьд ихээхэн ач холбогдолтой. Түүнчлэн шувуу ажигладаг, сонирхдог залуус олон болж байгаа энэ үед хотын ойролцоох усан сан, цөөрмүүдийн шувуудыг удаан хугацаанд тогтмол ажиглах нь шинжлэх ухааны хувьд мөн чухал юм.

Харамсалтай нь тус нуур Чингис хаан Олон улсын нисэх онгоцны буух, хөөрөх зурвас орчимд байрладаг учир агаарын хөлгийн аюулгүйн үүднээс нууруудыг булах асуудал сүүлийн жилүүдэд эрчимтэй яригдах болсон. Бид энэхүү өгүүлэлдээ цэвэршүүлэх байгууламжийн нуур орчмын шувуудын зүйлийн бүрдэл болон энэ нуурын шувуудын амьдралд үзүүлж буй ач холбогдол мөн тулгамдаж буй асуудлуудын талаар хөндлөө.

Арга зүй

Ногоон нуур нь Улаанбаатар хотын баруун хэсэг, Сонгино хайрхан дүүргийн нутагт, ус цэвэршүүлэх байгууламжийн цэвэршүүлсэн хаягдал уснаас бүрэлдэн бий болсон цөөрөм юм (Зураг 1). Энэ нууранд Дунд голын ус цутган цааш Сонгино хайрхан уулын зүүн бэлээр урсан Туул гол руу нийлдэг. Энэ орчмын усан сангуудын болон Туул голын дагуу шувууны судалгаа, ажиглалт өмнө нь цөөнгүй удаа хийгдсэн байдаг. Бид 2008-2015 оны хугацаанд энэ орчмын шувуудыг ажиглаж бүртгэсэн өөрсдийн болон бусад шувуу дотоод, гадаадын шувуу судлаачид, ажиглагчдын мэдээ баримтыг нэгтгэн өмнө нь хийгдсэн ажиглалтын үр дүнтэй харьцуулав. Шувуудын зүйлийн бүрдлийг гаргахдаа зургаар баталгаажуулсан ажиглалтуудыг Монголын шувуу ажиглагчдын клубын цахим групп, блог хуудас, мөн Монгол орны шувуудын чиглэлээр байнга мэдээлэл өгдөг Германы шувуу ажиглагч нарын блог хуудас, бусад гадны шувуу ажиглагч нарын аяллын тэмдэглэл зэрэг бүхий л боломжит мэдээллийн эх сурвалжуудыг шүүж ашигласан.




Зураг 1. Цэвэршүүлэх байгууламжийн “Ногоон нуур”-ын байршил

Үр дүн

Ногоон нуур, түүний орчмын шувууг Монголын шувуу ажиглагч, судлаачид 2008 оноос хойш идэвхитэй бүртгэж байгаа бөгөөд одоогоор 13 баг, 40 овгийн 187 зүйлийн шувуу бүртгэгдээд байна. Энэхүү шувуудыг ногоон нуур, түүний орчим дахь оршин амьдрах хэлбэрээр нь ангилан үзвэл дайран өнгөрдөг 56% (n=105),

нүүдлийн өндөглөдөг 21% (n=39), суурин 17% (n=31), өвөлждөг 6% (n=12) байна.

Үүнээс 22 зүйлийн шувуу нь Монгол улсын улаан ном, бүс нутгийн болон олон улсын улаан дансанд устаж байгаа, устаж болзошгүй, эмзэг, ховордож болзошгүй гэсэн зэрэглэлд багтсан байна (Зураг 2).



Зураг 2. Олон улсын болон бүс нутгийн улаан дансны үнэлгээ

Үүнээс Монгол улсын улаан номонд орсон 11 зүйл (Шийрэвдамба нар, 2013), зэрлэг амьтан ба ургамлын аймгийн ховор зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай (CITES) конвенцийн I хавсралтанд орсон цагаансүүлт нөмрөгбүргэд *Haliaeetus albicilla*, цэн тогоруу *Grus vipio*, II хавсралтанд орсон 8 зүйл байна (Мягмарсүрэн нар, 2014). Мөн зэрлэг амьтдын нүүдлийн зүйлүүдийг хамгаалах тухай (CMS) конвенцийн I хавсралтанд орсон 9 зүйл, II хавсралтанд орсон 11 зүйл байна (Лхагвасүрэн 2012) (Хүснэгт 1).

Ногоон нуур, түүний орчимд нийтдээ 43 зүйлийн шувууд үүрлэж байгаа ба тэдгээрийн мэдээллийг зүйл тус бүрээр дэлгэрэнгүй бичив.

Нүүдэллэн ирж үрждэг шувууд:

Хошуу галуу *Anser cygnoides* – Хошуу галуу үржиж байгаа талаарх анхны мэдээллийг 2011 оны зун бүртгэсэн бөгөөд нэг хос галуу тус нууранд 2 дэгдээхэйн хамт бүртгэгдсэн. Мөн тухайн жилийн намар нь нууранд бие гүйцсэн 6 хошуу галуу ажиглагдсан. Түүнчлэн 2012, 2013 онуудад тус бүр нэг хос үржсэн бол 2014

оны хавар 10 бодгаль бүртгэгдсэнээс хоёр хос үүрлэсэн байна. Харин 2015 оны зун 6 хос галуу үүрлэж 22 дэгдээхэйг бойжуулжээ.

Шарэлэгт хөмрөг *Emberiza aureola* – Дэлхийн хэмжээнд устах аюулд орсон зүйл. 2011 оны зун 3 бодгаль, 2013 оны хавар 2 бодгаль, зун нь буюу үржлийн үед нэг бодгаль, намар 8 сард бие гүйцсэн шувууд тухайн жилийн залуу шувуудын хамт байхыг бүртгэсэн. Харин энэ зүйл хөмрөгийн хосын тоог тогтоохоор 2015 онд нуурын зүүн хэсгийн бургастай шугуйд ажиглалт хийж нийт үржлийн 5 хосыг бүртгэж, үүр бүрийн байршлыг тодорхойлов.

Дорнын хулд *Circus spilonotus* – Энэ зүйл хулдыг үүрлэж байж болохыг Ганхуяг, Амархүү нар 2012 оны зун ажигласан боловч тухайн явалтаараа үүрийг нь олж чадаагүй. Харин 2015 онд нуурын зүүн болон зүүн урд хэсгээр байх зэгсэнд үүрлэсэн байхыг тогтоов.

Өвөгт тогоруу *Anthropoides virgo* - Нуурын баруун урд хэсэгт, далангийн хойд хэсгээр орчим үүрлэдэг. Хос үржлийн тогоруу энэ орчимд үүрлэж байгаа мэдээ сүүлийн 3

Хүснэгт 1. Ногоон нууранд ажиглагдсан ховор шувууд ба тэдгээрийн статус

№	Шинжлэх ухааны нэр	Монгол нэр	Оршин амьдрах хэлбэр	Бүс нутгийн үнэлгээ*	Олон улсын үнэлгээ*	Улаан Ном*	CITES	CMS
1	<i>Anser cygnoides</i>	Хошуу галуу	НӨ	ХБ	Э	-	-	I
2	<i>Anas falcata</i>	Гэээгт нугас	ДӨ	ХБ	ХБ	X	-	II
3	<i>Aythya ferina</i>	Улаанхүзүүт шумбуур	НӨ	АӨ	Э	-	-	II
4	<i>Aythya nyroca</i>	Ундар шумбуур	ДӨ	Э	ХБ	X	-	I
5	<i>Botaurus stellaris</i>	Усны бухшувуу	ДӨ	АӨ	АӨ	X	-	-
6	<i>Falco naumanni</i>	Зээрд шонхор	ДӨ	Э	АӨ	-	II	I
7	<i>Falco cherrug</i>	Идлэг шонхор	С	Э	УБ	-	II	I
8	<i>Haliaeetus albicilla</i>	Цагаансүүл нөмрөгбүргэд	Ө	ХБ	АӨ	X	I	I
9	<i>Gypaetus barbatus</i>	Ооч ёл	ДӨ	Э	ХБ	X	II	II
10	<i>Aegypius monachus</i>	Нөмрөг тас	ДӨ	АӨ	ХБ	-	II	II
11	<i>Aquila clanga</i>	Бор бүргэд	ДӨ	УБ	Э	НХ	II	I
12	<i>Aquila nipalensis</i> *	Хээрийн бүргэд	ДӨ	АӨ	УБ	-	II	II
13	<i>Otis tarda</i>	Хонин тоодог	ДӨ	Э	Э	X	II	I
14	<i>Grus vipio</i>	Цэн тогоруу	ДӨ	Э	Э	НХ	I	I
15	<i>Grus grus</i>	Хархираа тогоруу	ДӨ	ХБ	АӨ	X	II	II
16	<i>Vanellus vanellus</i> *	Умардын хавтгаалж	ДӨ	АӨ	ХБ	-	-	II
17	<i>Limosa limosa</i> *	Морин цууцал	ДӨ	АӨ	ХБ	-	-	II
18	<i>Numenius arquata</i> *	Морин тутгалжин	ДӨ	АӨ	ХБ	-	-	II
19	<i>Calidris ruficollis</i> *	Шартүрүүт элсэг	ДӨ	АӨ	ХБ	-	-	II
20	<i>Calidris ferruginea</i> *	Хадуур элсэг	ДӨ	АӨ	ХБ	-	-	II
21	<i>Anthus trivialis</i>	Ойн шийхнүүхэй	ДӨ	ХБ	АӨ	X	-	-
22	<i>Emberiza aureola</i>	Шарэлэгт хөмрөг	НӨ	ХБ	УБ	X	-	I

* Бүс нутаг болон олон улсын улаан дансны үнэлгээ: УБ-устаж болзошгүй, Э-эмзэг, ХБ-ховордож болзошгүй, АӨ-анхааралд өртөхөөргүй; Улаан ном: НХ-нэн ховор, Х-ховор; Оршин амьдрах хэлбэр: ДӨ-дайран өнгөрдөг, НӨ-нүүдлийн өндөглөдөг, С-суурин, Ө-өвөлждөг; *IUCN-ы 2015 оны шинэ ангилалаар нэмэгдсэн зүйлүүд

жилийн турш бүртгэгдсэн бөгөөд өндөг дарж буй тогорууг гэрэл зургаар баталгаажуулсан. 2013 оны 6 сард Б.Нямбаяр, Ж.Арчибалд нар дэгдээхэйтэй 4 хос тогоруу энэ орчим ажигласан байдаг.

Хөх дэглий *Ardea cinerea* - нуурын төв хэсэгт байх жижиг арлуудын хамгийн хойд хэсгийн зэгстэй арал дунд үүрлэдэг бөгөөд үүрэндээ буй залуу дэглийн зургийг шувууны гэрэл зурагчин Л. Жаргалсайхан дарж баталгаажуулсан.

Гангар хун *Cygnus cygnus* – Энэ зүйл хун Ногоон нуураас баруун зүгт 2.5 км зайд орших жижиг нууранд 2011-2014 онуудад тогтвортой үүрлэсэн. Хот төлөвлөлтийн дагуу Сонгины зүүн бэлд Авто машины зах барихтай холбоотой барилгын ажил энэ нуурын яг хажууд эхэлсэн учир 2015 онд хун үүрлээгүй.

Хондон ангир *Tadorna ferruginea*, бор нугас *Anas strepera*, зэрлэг нугас *Anas platyrhynchos*, гэээгт шумбуур *Aythya fuligula*, отгот шунгуур *Podiceps cristatus* ногоохон нугас *Anas crecca*, халзан түнжүүр *Fulica atra*, улаанхүзүүт шумбуур *Aythya ferina* зэрэг нугаснууд сүүлийн 3 жилийн ажиглалтаар тогтмол бүртгэгдсэн ба нуурын төв болон хойд хэсэгт байх арлуудаар үүрлэдэг.

Эгэл хараалай *Sterna hirundo*, улаанхөлт хөгчүү *Tringa totanus*, эгэл хилэнжигүүр *Himantopus himantopus*, нарийн хиазат *Charadrius dubius* зэрэг гол, нуурын эрэг орчмоор байршдаг зүйлүүд нуурын баруун урд хэсгийн эргийн ойролцоох бургастай жижиг арлуудаар үржлийн тохиолддог. Энэ талаар мөн Номадик Экспедишн компаний шувууны аяллын

жуулчид өөрсдийн цахим хуудсандаа бүртгэж зурагтай нь хамт оруулсан байна.

Бор тодол *Sturnus cineraceus* 2015 оны зун нуурын өмнөд хэсгээр байх төмөр замын гэрлэн дохионы төмөр баганы нүхэнд хоёр хос үүрлэсэн. Бөвөөлжин өвөөлж *Upupa epops*, хондлойцагаан ураацай *Apus pacificus*, хурын ураацай *Apus apus* зэрэг шувууд баруун талд байх барилгын хашаанд үүрлэдэг.

Хөх цэгцгий *Motacilla alba*, адууч чогчиг *Oenanthe oenanthe* зэрэг шувууд нуурын урд хэсгээр овоолсон цементэн хаягдлын завсар болон жижиг мэрэгчдийн нүхэнд үүрлэдэг нь бүртгэгдсэн.

Годлевскийн шийхнүүхэй *Anthus godlewskii*, боролзой богширго *Alauda arvensis*, бүжимч чогчиг *Oenanthe isabellina* зэрэг шувууд нуурын баруун урд хэсгийн хээрээр тогтмол үүрлэнэ.

Бургасны ураншувуу *Remiz coronatus*, шарэлэгт хөмрөг *Emberiza aureola* зэрэг шувууд нуурын зүүн хэсгийн бургастай шугуйд үрждэг бол дорнын охилбялзуухай *Acrocephalus orientalis*, гүймхий шатансүүлт *Locustella certhiola*, хээрийн охилбялзуухай *Acrocephalus agricola*, шөвгөн хараалж *Gallinago gallinago*, оодон түнжгэр *Porzana pusilla* зэрэг зэгс, өндөр өвстэй намгархаг газар шүтэн үрждэг шувууд мөн энэ орчимд үрждэг байна. Английн судлаач Эндриу Диксон 2014 онд *Porzana pusilla* –ийн хоёр үүрийг олж зургийг нь авсан ба нэг үүртэй ангаахай нь усанд живсэн байсан байна.

Суурин болон үржлийн шувууд:

Начин шонхор *Falco tinnunculus* - Нуурын баруун талд байх барилгын хашаан доторх томоохон усны хоолойнуудын байгууламж дээрх хар хэрээний үүрэнд үрждэг.

Идлэг шонхор *Falco cherrug* - Нуурын хойд хэсэгт байх цахилгаан дамжуулах өндөр хүчдэлийн анкер шон дээр зассан хон хэрээний үүрэнд 2008-2010 оны хугацаанд үүрлэж байсан гэмдэглэл байгаа хэдий ч 2011 онд үүрийг цахилгааны компаний ажилчид буулгаснаас хойш энэ орчимд дахин үүрлээгүй.

Хон хэрээ *Corvus corax* - Нуурын хойд хэсэгт байх цахилгаан дамжуулах өндөр хүчдэлийн анкер шон дээр үүрлэж үржиж байгаад сүүлийн жилүүдэд үүр засаагүй.

Алаг шаазгай *Pica pica* - Нуурын зүүн урд хэсгийн бургасанд тогтмол үүрлэдэг.

Улаанхошуут жунгаа *Pyrhacorax pyrrhacorax* - Нуурын баруун хойд хэсэгт байх нефть байгууламжийн хашаанд доторхи хуучин байшингуудын дээвэрт үүрлэдэг.

Номин хөхбүх *Parus cyanus*, хээрийн боршувуу *Passer montanus*, үүрэн сүүлтзана *Uragus sibiricus* зэрэг жижиг шувууд нуурын зүүн өмнөд хэсгийн бургастай шугуйд үүрлэдэг. 2015 оны зун бургасанд ажиглалт хийж хоол зуусан хоёр хос номин хөхбүх мөн 3 хос үүрэн сүүлтзана олж бүртгэсэн байна.

Ногоон нуур түүний орчим бүртгэгдсэн нийт шувуудын жагсаалтыг доорх холбоосоор орж үзнэ үү: www.wsc.org.mn/mjo/20160214

Хэлэлцүүлэг

Хот суурин газар өргөжин тэлэхийн хэрээр шувуудын зүйлийн тоо хэрхэн өөрчлөгдөж байгаа талаар судлаачид ихээхэн ач холбогдол өгч ажиглалт явуулж байжээ. Улаанбаатар хотын шувуудын талаар нэлээдгүй олон судалгааны ажлууд байдаг бөгөөд хот орчмын шувуудын экологи, практик холбогдол (Болдбаатар 1996, 1997, 2002b), хэрээний овгийн шувууд, тэдгээрийн оршихуй Болдбаатар (2002b), мөн Богдхан уулын шувууд (Цэвээнмядаг 1992, Болдбаатар 1997, Шар нар 2008), хотын цэцэрлэгт хүрээлэнгүүдийн шувууд (Цэнгэг 1994) зэрэг сэдэвт бүтээлүүд байдаг.

Монгол орны нутаг дэвсгэрт нийт 476 зүйлийн шувууд тэмдэглэгдсэн байдаг (Болд нар, 2007) бол Улаанбаатар хотод 14 баг 40 овгийн 110 төрөлд хамаарах 204 зүйлийн шувууд бүртгэгдсэн байна (Болдбаатар 2002a). Харин Болд нар (2000) Улаанбаатар хотын усан сангуудад тохиолдох шувуудын талаар бүтээл хэвлүүлсэн бөгөөд үүндээ цэвэршүүлэх байгууламжийн уснаас бүрдэж бий болсон цөөрмийн талаар тусгайлан бичсэн байдаг. Энэхүү өгүүлэлд 1995-2000 оны хугацаанд ажигласан таван жилийн мэдээ оруулсан ба тус хугацаанд цэвэршүүлэх байгууламжийн усан санд 10 багийн 20 овгийн 61 зүйлийн шувуудыг бүртгэжээ. Эдгээрээс 17 зүйл нь тус нуур болон түүний орчимд үрждэг гэсэн бөгөөд үүнээс 4 зүйл нугас болох Хондон ангир (*Tadorna ferruginea*), зэрлэг нугас (*Anas platyrhynchos*), бор нугас (*Anas strepera*), халзан түнжүүр

(*Fulica atra*), мөн эгэл хараалай (*Sterna hirundo*) уг нууранд зусаж үүрлэдэг гэжээ. Түүнчлэн хондон ангир (*Tadorna ferruginea*) 1000 орчим тоотойгоор өвөлжиж байсан талаар Болд нар (2000) бүтээлдээ дурьдсан байдаг. Дээрх таван зүйлийн үржиж буй шувуудаас ажиглахад энэ нуур нь үүсээд удаагүй, үүрлэх таатай орчин бүрэн бүрдээгүйтэй холбоотой гэжээ (Болд нар, 2000).

Сүүлийн 8 жилийн ажиглалтын мэдээг шүүж үзэхэд тус нуур болон түүний орчимд нийт 187 зүйл шувуу бүртгэгдсэнээс 43 зүйл нь үржлийн ба 6 зүйл нугас өвөлжиж байна. Зөвхөн үржлийн шувуудын мэдээг харьцуулж үзвэл Ногоон нуур сүүлийн 15 жилийн дотор үржлийн болон нүүдлийн мөн өвөлждөг шувуудын хувьд байрших таатай орчныг ихээр бий болгожээ гэж үзэж болохоор байна. Энэ нууранд 15 жилийн өмнө зөвхөн нэг зүйл нугас болох хондон ангир өвөлждөг (Болд нар 2000, Болдбаатар 2002а) тухай баримт байгаа бол сүүлийн жилүүдэд 6 зүйл нугас энэ нуур, түүний орчмын жижиг голуудад өвөлжиж байгаа нь зарим нүүдэллэдэг зүйлүүдэд тохиромжтой орчин бүрдсэн байж болох юм. Энэ нууранд анхны үржлийн нэг хос хошуу галуу 2011 онд бүртгэгдсэн бол 2015 оны байдлаар 5 хос галуу нийт 24 дэгдээхэй амжилттай бойжуулсан. Хошуу галуу энэ бүс нутагт олон жилийн дараа эргэн үүрлэж байгаа боловч. Учир нь Болд нар (2000)-ын 5 жилийн ажиглалтын хугацаанд хошуу галуу бүртгэгдээгүй бол Богд Хан уулын ар хөндий Туул голын дагуу усны нөмрөгбүргэд *Haliaeetus leucorhphus*, Хошуу галуу *Anser cygnoides* зэрэг шувууд үүрлэн үрждэг байсан талаар (Козлов 1924, Тугаринов 1929, Козлова 1930) нар бүтээлдээ дурьджээ. Түүнчлэн 1950 оны үед Буурал галуу *Anser fabalis* маш олон тоотойгоор Сонгины уулын зүүн хөндийгөөр дайрч өнгөрдөг талаарх баримт байна. Үүний талаар энэ орчимд шувуу агнадаг байсан нутгийн хүмүүс ярьжээ (Болд нар, 2000). Үүнээс ажиглахад Сонгино уулын зүүн хөндий олон жилийн өмнө нүүдлийн шувуудын дайран өнгөрдөг чухал нутаг байсан байж болох юм. Гэтэл 1960 оноос хойш Буурал галууны нүүдэл энэ хөндийд дахин үзэгдэхээ больсон бөгөөд үүнийг 1960-1980 оны Улаанбаатар хотын барилгажилт эрчимтэй хөгжиж тус бүс нутагт хүний нөлөө ихэссэн мөн буурал галуу олноор бууц суух орон зай байхгүй болсонтой холбоотой гэж

үзэж байна. Мөн Болд нар (2000) Улаанбаатар хотын хаягдал ус цэвэршүүлэх байгууламжийн алдагдах усны хэмжээ аажмаар ихсэж, түүний бохирдлыг тунгаан цэвэршүүлэх тусгай байгууламжууд бий болсноор ус намгийн шувуудын нүүдлийн эртний зам сэргэх тал ажиглагдаж байна хэмээжээ.

Энэ нуурыг цаашид эко парк болгон хөгжүүлэх улмаар шувуу ажиглагчдыг Монголд хөгжүүлэхэд чухал ач холбогдолтой талаар дурьдсан байна. Энэ орчмын нуурууд өнөөдөр Монголын шувуу ажигладаг, сонирхдог олон иргэдийн очих дуртай газар нэгэнт болж жил бүр олон иргэд нүүдлийн шувуудыг ажиглахаар зорьдог болсон (Ганхуяг нар, 2014). Харамсалтай нь сүүлийн жилүүдэд Чингис хаан Олон улсын нисэх онгоцны аюулгүйн албанаас энэ орчмын нуур, цөөрмүүдийг дарж булуулах талаар идэвхитэй яригдаж байгаа боловч өртөг өндөртэй ажил учир шийдвэр гаргаж чадахгүй байгаа юм.

Шувуу ажигладаг иргэдийн хувьд хотод хамгийн ойр газар учир цэвэршүүлэх байгууламжийн нуурыг түшиглэн Шувуу ажиглах эко парк болгон ашиглах сонирхол их байдаг. Хэдий тийм ч энэ нуур онгоцны нислэгийн хөөрөх, буух зурвас орчимд байрлах учир нуурын шувууд агаарын хөлөгтэй мөргөлдөж асар том сөрөг үр дагавар үүсгэх аюултай. Хот суурин газар нисэх онгоцны буудал зэрэг томоохон дэд бүтцүүдийг барихдаа анхнаас нь Байгаль орчны судалгааг шаардагдах стандарт аргачлалын дагуу хийлгэж, агаарын хөлгийн аюулгүй байдлыг хангахаар төлөвлөх шаардлагатай байдаг (Bradley *et al*, 2013). Тухайлбал Туул голын шувуудын талаарх мэдээлэл ялангуяа Сонгино уулын зүүн бэл хөндий нь нүүдлийн шувуудын дамжин өнгөрдөг нутаг болдог талаархи бүтээлүүд хэвлэгдэж байсан (Козлов 1924, Тугаринов 1929, Козлова 1930). Гэтэл энэ чиглэлийн судалгааг хийлгээгүйн улмаас голын хөндий, ус намгаргах газар буюу шувууд нүүдлийн үедээ дайран өнгөрдөг мөн зусаж үрждэг энэ нутгийг агаарын хөлөг хөөрөх, буух зурвас болгон хөгжлийг төлөвлөсөн нь өнөөдрийн энэ хүнд нөхцлийг үүсгээд байна. Иймд Чингис хаан Олон улсын нисэх онгоцны удирдлагаас энэ асуудлаар шувуу судлалын мэргэжлийн байгууллагуудтай хамтран ажиллах шаардлагатай.

Талархал

Энэхүү өгүүллийг бичихэд арга зүйн зөвлөгөө өгсөн ШУА, Ерөнхий ба сорилын биологийн хүрээлэнгийн Шувуу, шавж судлалын лабораторийн эрдэм шинжилгээний тэргүүлэх ажилтан Доктор Н.Цэвээнмядагт талархсанаа илэрхийлье. Мөн Монголын шувуу ажиглагчдын клубын бүх гишүүддээ талархал илэрхийлье!

Ашигласан бүтээл

Bradley, F. B., M. S. Paige, and A. M. James. 2013. Avian Survey Methods for Use at Airports. Wildlife Damage Management, Internet Center for University of Nebraska Lincoln.

Болд, А., Ш. Болдбаатар, Г. Майнжаргал. 2000. Улаанбаатар хотын усан сангууд, тэдгээрийн шувуудын амьдралд үзүүлэх холбогдол. Шинжлэх ухааны академи, Биологийн хүрээлэнгийн эрдэм шинжилгээний бүтээл. 22:137-140.

Болд, А., Н. Цэвээнмядаг, Ш. Болдбаатар, Г. Майнжаргал. 2007. Монгол орны шувууны зүйлийн нэрийн арван хэлний толь. Төрийн хэлний зөвлөл, Шинжлэх ухааны академи Хэл зохиолын хүрээлэн, Биологийн хүрээлэн. Улсын нэр томъёоны бичиг. 2:150.

Болдбаатар, Ш. 1996. Улаанбаатар хот, түүний орчмын зарим шувуудын тухай. Улаанбаатар.

Болдбаатар, Ш. 1997. Улаанбаатар хот, түүний орчмын шувуудын экологи, практик холбогдол, биологийн ухааны доктор (PhD) зэрэг горилсон бүтээл.

Болдбаатар, Ш. 2002а. Улаанбаатар хот, түүний орчмын шувуудын экологи, практик холбогдол. Монголын Шинжлэх Ухааны Академи Биологийн Хүрээлэн, Монгол орны шувуу, хоёр нутагтан, мөлхөгчид. №1:77-89.

Болдбаатар, Ш. 2002б. Улаанбаатар хотод тархсан хэрээний овгийн шувууд, тэдгээрийн оршихуй. Монголын Шинжлэх Ухааны Академи Биологийн Хүрээлэн, Монгол орны шувуу, хоёр нутагтан, мөлхөгчид. №1:50-63.

Ганхуяг, П., П. Амартүвшин, Х. Түмэндэлгэр. 2014. Монголд шувуу ажиглах аяллын өнөөгийн байдал, тулгамдаж буй асуудал, шийдвэрлэх боломж. Тоодог: Монголын шувуу судлалын сэтгүүл. №1:42-47.

Козлов, П. К. 1924. Монгольский заповедник Богдо-Ула. Известия Русского географического общества №1:169-173.

Козлова, Е. В. 1930. Птицы Юго-Западного Забайкалья, Северной Монголии и Центральной Гоби. Изд. АН СССР. Ленинград:379с.

Лхагвасүрэн, Б. 2012. Зэрлэг амьтдын нүүдлийн зүйлүүдийг хамгаалах тухай конвенцийн тайлан. Улаанбаатар.

Мягмарсүрэн, Ш., С. Гомбобаатар, М. Мөнхжаргал, Н. Конабой. 2014. Зэрлэг амьтан ба ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай конвенцийн үндэсний анхдугаар тайлан. Улаанбаатар хот, Монгол улс.

Тугаринов, А. Я. 1929. Северная Монголия и птицы этой страны. Pages 145-236 Предварительный отчет зоологической экспедиции в Северную Монголию за 1926 г.

Цэвээнмядаг, Н. 1992. Богд уулын шувуу. Улаанбаатар.

Цэнгэг, П. 1994. Улаанбаатар хот орчмын цэцэрлэгийн шувууд. Pages 30-36 Их, дээд сургуулийн эрдэм шинжилгээний шилдэг бүтээлийн эмхэтгэл. МУАУИС.

Шар, С., Р. Самъяа, С. Гомбобаатар, Н. Цэвээнмядаг, Н. Цагаанцоож, Р. Тунгалаг. 2008. Богдхан уул, түүний орчмын зонхилох амьтан, ургамал. Pages 42-119. Соёмбо Принтинг, Улаанбаатар хот.

Шийрэвдамба, Ц., Я. Адъяа, Э. Ганболд, Г. Цэрэнханд. 2013. Монгол улсын улаан ном. Байгаль орчин ногоон хөгжлийн яам, Улаанбаатар хот.